

**УУР АМЬСГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ ХАРИУЦСАН ТЕХНОЛОГИЧ ИНЖЕНЕРИЙН
АЖЛЫН БАЙР /АЛБАН ТУШААЛ/-ЫН ТОДОРХОЙЛОЛТ**

А.ТАНИЛЦУУЛГА

1.Байгууллагын нэр: Өвөрхангай аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв	2. Нэгжийн нэр: Цаг уур, орчны технологийн хэлтэс	
3. Ажлын байрны нэр: Уур амьсгалын үйлчилгээ хариуцсан технологич инженер	3.1. Албан тушаалын ангилал: Төрийн үйлчилгээ	3.2. Албан тушаалын зэрэглэл: ТҮМ-6
4. Ажлын байрыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр: УЦУОШТөвийн дарга ЦУОТХэлтсийн дарга МҮХэлтсийн дарга	4.1.Албан тушаалын ангилал: Төрийн үйлчилгээний Төрийн үйлчилгээний Төрийн үйлчилгээний	4.2.Албан тушаалын зэрэглэл: ТҮМ-11 ТҮМ-7 ТҮМ-7
5. Ажлын байрны шууд харьяалан удирдах албан тушаал:	5.1. Албан тушаалын нэр: Уур амьсгалын үйлчилгээ хариуцсан инженер Цаг уурын шинжилгээний өртөө, харуулын техникч	5.2.Албан тушаал эрхлэгчдийн тоо: 2 46

Б.ЧИГ ҮҮРЭГ

1.Ажлын байрны зорилго :	Цаг уурын шинжилгээний хөтөлбөрт ажлыг хийж гүйцэтгэхэд мэргэжлийн удирдлагаар хангах, хяналт тавих, хэмжлийн нэгдмэл байдлыг хангаж ажиллах, шүүмж шалгалтыг онолын өндөр түвшинд хийж, инженер, техникч нарын хөдөлмөрийн гэрээний биелэлтийг хангуулах, цаг уурын мэдээ, мэдээллээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хангаж ажиллахад оршино.	
2.Ажлын байрны үндсэн зорилт :	2.1 Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт :	
1.Цаг уурын бүх төрлийн шинжилгээний хөтөлбөрт ажил болон өртөө, харуулын ажилд хяналт тавьж, өдөр тутмын удирдлагаар хангах	Шинжилгээний хөтөлбөрт ажил тасалдалгүй, бүрэн хийгдсэн байна.	
2.Сар бүрийн тайланд шүүмж шалгалт хийж, инженер, техникчдын ажилд дүгнэлт өгч, салбарын шинжилгээний ажлын талаар сар, улирал, хагас, бүтэн жилээр хэлтсийн хурлаар тайлагнах	Шинжилгээний ажлын чанар сайжирна	
3. Салбаруудын шинжилгээний ажилд сар бүр үнэлэлт өгч, хариу зааварчилгаа, зөвлөмж, мэргэжлийн хичээлийг системтэй явуулж, алдааг багасгах талаар улиралд 2-оос доошгүй удаа зааварчилгаа бичиж хүргүүлсэн байх	Салбаруудын ажлын чанарт ахиц гарч, технологи мөрдөлт сайжирна.	
4. Шалган туслах ажлын удирдамж боловсруулан газрын даргаар батлуулж, удирдамжийн дагуу салбаруудад ажиллаж, технологи мөрдөлтөнд хяналт тавих, мэргэжлийн арга зүйн заавар зөвлөгөөг өгөх	Ажиглалтыг технологийн дагуу хийж, шинжилгээ судалгааны ажил хийгдэх боломж бий болно	
5. Шүүмж шалгалтыг онолын өндөр түвшинд хийж олон жилийн харьцуулалт хийх эмхэтгэл судалгааг хийх	Ажиглалтын чанар дээшилнэ. Анхан шатны нэгжид ажиллаж байгаа ажилчдын мэдлэг сайжирна.	
6. Цаг уурын инженерүүд, ХААЦУ-ын инженер болон ЦУОТХ-ийн дарга амарсан, ямар нэг шалтгаанаар ажилдаа ирээгүй тохиолдолд орлон ажиллаж, холбогдох арга хэмжээг авах	Ажлын тасалдал гарахгүй, боловсон хүчний хөрвөж ажиллах чадвар дээшилнэ.	
7. Харьяа салбаруудад шинээр ажилд орж буй хүмүүсийг сургалтын төлөвлөгөө гарган дадлагажуулах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, заавар зөвлөгөө өгч, шалгалт авч, УЦУОШГ-ын даргын зөвлөлд танилцуулах	Ажиллах боловсон хүчний чадвар дээшилнэ.	
3.Ажлын байрны үндсэн үйл ажиллагаа:	3.1.Хугацаа, хуваарь	

<u>Ажлын байрны 1 дүгээр үндсэн зорилтын хүрээнд :</u>		
1.1 Хөтөлбөрийн дагуу ажиглалт, хэмжилтүүд хугацаандаа бүрэн хийгдэж буйд хяналт тавих,		30
1.2 Технологи зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох		
<u>Ажлын байрны 2 дугаар үндсэн зорилтын хүрээнд :</u>		
2.1 Шинжилгээний ажиглалтын материалд анхан шатны боловсруулалтыг цэвэр нямбай хугацаанд нь чанартай хийлгэх, ажиглалтын технологийн горимыг мөрдүүлэх ажлыг зохион байгуулах		20
2.2 Өөрийн мэдлэг мэргэжлээ байнга дээшлүүлж, шинээр ажилд орж буй хүмүүст сургалтын төлөвлөгөө гаргаж, газрын даргаар батлуулж, хичээл зааж дадлагажуулах		
2.3 Хариуцсан салбарын хийсэн ажлын тайланг бичиж, тайлагнах		
<u>Ажлын байрны 3 дугаар үндсэн зорилтын хүрээнд :</u>		
3.1 Техникч ямар нэг хүндэтгэх шалтгаанаар ажиллаагүй нөхцөлд орлон ажиллана.		10
3.2 Салбаруудаас ирсэн тайланг хугацаанд нь техник, шүүмж шалгалтыг хийж УАНС-т хүргүүлэх, анхан шатны материалд шүүмж шалгалтыг хийж, хариу зааварчлагаа өгөх, илэрсэн алдаа дутагдлын талаар арга зүйн зөвлөгөө өгч, холбогдох арга хэмжээг авах		
3.3 Шинжилгээний ажил сайжруулахад санаачлагатай бүтээлч ажиллах		
<u>Ажлын байрны 4 дүгээр үндсэн зорилтын хүрээнд:</u>		
4.1 Онолын болон техник шалгалт хийх заавар журам ном хэвлэлийг цаг хугацаанд нь хүргүүлсэн байх / төв орон нутагт/		10
4.2 Удирдамжийн дагуу шалган туслах ажлыг хийх, ажиглалтын технологи мөрдөлтөнд хяналт тавих		
4.3 Шалгалтаар илэрсэн алдааг засах, энэ талаар техникч нарт заах мэргэжлийн хичээлийн хөтөлбөр гаргаж улиралд 2 удаа хичээл зааж шалгалт авах.		
<u>Ажлын байрны 5 дугаар үндсэн зорилтын хүрээнд:</u>		
5.1 Шүүмж шалгалтын мөрөөр олон жилийн харьцуулалт хийж, судалгааны материалтай болох		5
<u>Ажлын байрны 6 дугаар үндсэн зорилтын хүрээнд:</u>		
6.1 Инженер ямар нэг хүндэтгэх шалтгаанаар ажилдаа ирээгүй нөхцөлд орлон ажиллах		5
6.2 Ажлын тасалдал доголдол гаргахгүй ажиллах		
<u>Ажлын байрны 7 дугаар үндсэн зорилтын хүрээнд:</u>		
7.1 Сургалтын төлөвлөгөө гаргаж, батлуулах		10
7.2 Шинээр ажилд орж буй ажилтаныг дагалдуулан дадлагажуулах		
7.3 Заасан хичээлийн дагуу тест боловсруулан шалгалт авч, үр дүнг газрын даргын зөвлөлд танилцуулах		
<u>Ажлын байрны бусад зорилтын хүрээнд:</u>		
1. УЦУОШТ, хэлтсээс зохион байгуулсан олон нийтийн ажилд бусдыгаа манлайлан идэвхтэй оролцох		10
2. Эрхэлсэн ажлын талаар төр захиргааны байгууллагаас гаргасан хууль, эрх зүйн баримт бичиг, заавар, удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, санал хүсэлтийг хүлээн авч шуурхай шийдвэрлэх		
3. “Монгол улсын Төрийн албан хаагчийн эрхэмлэх 9 зүйл”, бусад хуулийн заалтын хэрэгжилтийг хангаж ажиллах		
4. Удирдлагын манлайллыг хангах, мэдлэг боловсролоо байнга дээшлүүлж, шинээр нэвтэрч байгаа технологи, программ хангамжинд суралцах, судалгааны ажил хийж үр дүнг нэгтгэн боловсруулах		

В.ТАВИГДАХ ШААРДЛАГА

1.Ажлын байранд тавигдах шаардлага:	1.1 Ерөнхий шаардлага:	Үзүүлэлт	Чухал шаардлагатай	Шаардлагатай
		Боловсрол	Дээд боловсролын бакалавраас доошгүй	Дээд боловсролын магистраас доошгүй
		Мэргэжил	Цаг уурын инженер	Цаг уурч
		Мэргэшил	Цаг уурын чиглэлээр мэргэшсэн байх	- Цаг нарийн баримталдаг байх -Хүнийг манлайлах чадвартай байх
		Туршлага	Цаг уурын салбарт 5-с доошгүй жил ажилласан байх	Тухайн салбарт 3-с доошгүй жил ажилласан байх

